

ШХАБ-ын динамик төлөв, хөгжлийн үе шатуудад хийсэн шинжилгээ

Нямжавын Соёлгэрэл

Төвийн дарга, soyolgerel@iss.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

ОХУ, БНХАУ, БНКАЗУ, БНКирУ, БНТажУ “Хилийн бүсэд итгэлцлийг бэхжүүлэх тухай хэлэлцээр”-т БНХАУ-ын Шанхай хотноо 1996 онд гарын үсэг зурснаар “Шанхайн тав” хэмээх үйл явц эхэлсэн. Эхэн үедээ энэхүү бүтцийн үйл ажиллагаа цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудалд төвлөрч байсан. Улмаар эдгээр улс хамтын ажиллагаагаа илүү институцичлэх шийдвэр гарган, Узбекистанаар бүл нэмж, 2001 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ыг байгуулснаа зарласан юм. Түүнчлэн 2002 онд “ШХАБ-ын Харти”-д гарын үсэг зурснаар ШХАБ нь Төв Азийн аюулгүй байдлын нийтлэг сорилтыг шийдвэрлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих зорилготой Засгийн газар хоорондын улс төрийн зөвлөлдөх механизм болсон билээ.

Өнгөрсөн хугацаанд Энэтхэг, Пакистан, Иран болон Беларусийг бүрэн эрхт гишүүнээр элсүүлэн, өргөжөөд буй. ШХАБ нь гишүүдийнхээ яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны индэр, бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагатай харилцах нэг формат төдийгүй Евроазийн тогтвортой, аюулгүй байдал, хөгжлийг дэмжих бүс нутгийн томоохон механизм болж төлөвшиж байна.

Түлхүүр үгс: Бүс нутгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдал, том гүрнүүд, эдийн засгийн ашиг сонирхол

Нэг. ШХАБ-ын хөгжлийн үе шатууд

ШХАБ аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хязгаарлагдмал механизмаас эхлэн, өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах бүс нутгийн байгууллага болон хөгжихөөр зорьж буй олон талт хувьслын үйл явц юм. Евроазийн хамтын ажиллагаа, тогтвортой байдлын төлөөх яриа хэлэлцээний тавцан гэдгээ тууштай илэрхийлж ирсэн түүний хөгжил, төлөвшилд шууд, шууд бус олон хүчин зүйл нөлөөлсөн. Геополитикийн өөрчлөлтүүд, институцийн дотоод дахь үзэгдэл, үйл явц болон гадаад орчны дарамт зэрэг хүчин зүйлийн улмаас ШХАБ хөгжлийн ямар үе шатуудыг туулсныг өгүүллийн энэ хэсэгт авч үзье. Эдгээр нь:

- Байгуулагдсан буюу эхэн үеийн институцилал (2001-2004);
- Бэхэжсэн буюу өргөтгөсөн үйл ажиллагаа (2005-2012);

- Өргөжсөн буюу тэлэлт, геополитикийн шилжилт (2013-2017);
- Төрөлжсөн буюу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинэ сорилтуудтай тулгарч буй (2018 оноос өнөөг хүртэл) зэрэг юм.

Эхэн үеийн институцчиллийн үе шат (2001-2004): ШХАБ-ыг анх 2001 онд байгуулсан нь “Шанхайн тав”-ын аюулгүй байдлын хамтын ажиллагааны хүрээг институцийн түвшинд албан ёсоор баталгаажуулсан үйл явдал болов. Энэхүү эхний үе шат байгууллагын суурь зарчмуудыг хуульчлах, үндсэн бүтэц, байгууллагын механизмыг бүрдүүлэх гэсэн хоёр үндсэн зорилтод төвлөрч байлаа.

ШХАБ-ын Дүрэм (Charter)-ийг 2002 онд баталж, байгууллагын хууль эрх зүйн үндсийг тавьсан бөгөөд “Шанхайн оюун санаа” хэмээх үнэт зүйлийн хүрээг байгууллагын удирдах зарчим болгон тунхаглав. Бүрэн эрхт байдал, тэгш эрх, бусдын дотоод хэрэгт үл оролцох, жанжлалыг эсэргүүцэх зэрэг зарчим нь “жижиг” гишүүдийн дотоод улс төрийн тогтвортой байдлыг хамгаалах сонирхол болон тэргүүлэгч улс болох Орос, Хятадын олон талт дэг журам тогтоох өргөн хүрээний үзэл санааны илэрхийлэл болж байв (Thomas 2008 60(8)).

Институцийн тухайд 2004 онд Нарийн бичгийн дарга нарын газрыг Бээжинд, Терроризмын эсрэг бүс нутгийн бүтэц (РАТС)-ийг Ташкентэд тус тус байгуулав. Энэ хоёр бүтэц ШХАБ-ыг түр зуурын хамтын ажиллагааны бүлгээс байнгын ажиллагаатай хэлбэрт шилжүүлэх чухал алхам байлаа. Энэ үе 2001 оны есдүгээр сарын 11-ний халдлага болон Афганистанд эхлүүлсэн Америкийн ажиллагааны дараах геополитикийн нөхцөлтэй давхцаж байв. Тухайн үед Төв Азид цэргийн бааз байгуулах зөвшөөрлийг Америкт Узбекистан, Киргизийн талаас өгсөн бөгөөд ийнхүү ШХАБ-ын гишүүн улсууд Америктай тодорхой хэмжээнд хамтран ажиллаж байсан. Гэвч 2000-аад оны дунд үеэс ШХАБ АНУ-ын урт хугацааны цэргийн оролцоог шүүмжилж, түүнийг “гадаадын хөндлөнгийн оролцоо” хэмээн тодорхойлох болсон. Энэ хоёрдмол байр суурь нь гадаад хүчин зүйлүүд хэрхэн ШХАБ-ын аюулгүй байдлын хамтын ажиллагааг түргэсгэсэн болохыг тодорхой харуулдаг. Ингэснээр энэхүү анхны үе шат ШХАБ-ын хууль эрх зүйн, институцийн, үнэт зүйлийн суурийг тавьж, олон улсын аюулгүй байдлын хэлэлцүүлэгт өөр дуу хоолой бүхий альтернатив оролцогч болох нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Өргөтгөсөн үйл ажиллагааны үе (2005-2012): Энэ хугацаанд ШХАБ байгуулагдах үе шатнаасаа үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэх шатанд шилжсэн. Энэ явцад дараах гурван гол хандлага ажиглагдсан.

Нэгдүгээрт, ШХАБ цэргийн хамтарсан сургуулилтуудаа өргөтгөж эхэлсэн. “Энхийн ажиллагаа” хамтарсан сургуулилтыг 2003 оноос эхлүүлж, 2007 болон 2009 онд оргилдоо хүрсэн нь цэрэг, батлан хамгаалах салбар дахь байгууллагын хамтын ажиллагааны чадамжийг тодорхой харуулсан. Албан ёсны тайлбарт хамтарсан сургуулилт нь терроризмын эсрэг чиглэсэн гэж байсан ч бодит байдал дээр ердийн цэргийн чадавхыг харуулах, Хятад, Оросын цэргийн түншлэлийг гүнзгийрүүлэхэд нөлөөлсөн.

Хоёрдугаарт, ШХАБ-ын үйл ажиллагааны хүрээ аюулгүй байдлын хүрээнээс тэлсэн явдал юм. “Олон талт худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг 2003 онд баталсан нь бүс нутгийн эдийн засгийн интеграцийн зорилгыг илэрхийлэл болсон ч бодитоор хэрэгжээгүй. Гэсэн хэдий ч энэ баримт бичиг дэд бүтцийн хөгжил, эрчим хүчний хамтын ажиллагаа, худалдааг хөнгөвчлөх зэрэг хөгжлийн замын зураглал болсон. Мөн 2008 оны ШХАБ-ын Их сургууль болон залуучуудын солилцоо зэрэг соёлын санаачилгууд уламжлалт дипломат ажиллагаанаас гадна ШХАБ-ын дотоодод үнэт зүйл бүрдүүлэх, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх зорилготой байв

Гуравдугаарт, ШХАБ ажиглагч улсуудыг элсүүлж, хүрээгээ өргөтсөн. Тухайлбал: Монгол (2004), Иран, Энэтхэг, Пакистан (2005), Афганистан (2012) ажиглагчийн статустайгаар нэгджээ. Мөн Турк, Шри Ланк, Беларусь зэрэг улстай “яриа хэлэлцээний түнш”-ийн хүрээг тогтоож, олон улсын түвшинд байгууллагын нэр хүндээ өсгөсөн.

Энэ үед тэргүүлэгч улсуудын хоорондын анхны зөрчил ил гарав. Бээжин цэрэг, батлан хамгаалахын хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, эдийн засгийн интеграцийг урагшлуулах, ялангуяа ШХАБ-ын Хөгжлийн банк байгуулах санаачилга гаргасан. Харин Москва үүнд болгоомжилж, эдийн засгийн төслүүдийг ЕАЭЗХ, цэрэг батлан хамгаалахын хамтын ажиллагааг ХАБГБ-ын хүрээнд хэрэгжүүлэхийг илүүд үзсэн. Ийнхүү хоёр гүрний зөрчилдсөн байр суурь ШХАБ-ыг эдийн засаг эсвэл батлан хамгаалахын нэгдмэл орон зай болон төлөвших боломжийг хязгаарлажээ (Tiezzi 2015).

Дүгнэвэл: энэхүү хоёр дахь үе шатанд ШХАБ бүтцийн хувьд бэхжиж, үйл ажиллагааны чиглэлээ өргөтгөж, олон улсын тавцанд нэр хүндээ өсгөсөн боловч тунхаг, бодит үйл ажиллагааны хоорондын зөрчил буюу “хэрэгжилтийн зөрүү” илт ажиглагдах хандлагатай болжээ.

Тэлэлт, геополитикийн шилжилтийн үе (2013-2017): ШХАБ-ын хөгжилд 2013-2017 он бол шинэ үе рүү алхсан шилжилтийн үе шат болж, шинэ гишүүдээр өргөжиж, дэлхийн геополитикийн орчны өөрчлөлтийн нөлөөнд автсан он цаг байлаа. Геополитикийн хувьд энэхүү үе шат хоёр чухал үйл явдалтай давхацсан. Нэгдүгээрт, 2013 онд БНХАУ “Бүс ба Зам” санаачилгыг зарласнаар Евроазийн дэд бүтцийн төслүүдийг ШХАБ-ын хүрээнд уялдуулах шинэ стратегийн боломжийг бүрдүүлсэн. Хоёрдугаарт, 2014 оны Крымийн хямрал Орос, Өрнөдийн харилцааг хурцатган, Оросыг олон төрлийн хориг арга хэмжээний хүлээсэнд оруулсан. Энэ нөхцөлд ШХАБ Хятадын тухайд “Бүс ба Зам” санаачилгад Төв Азийн улсуудыг нэг мөр нэгтгэх, харин Оросын тухайд Евроазийн түншлэлийг багатгах тавцан болсон юм (Kaczmarek 2017 93: 6). Энэ үеийн хамгийн чухал үйл явдал бол Энэтхэг, Пакистан хоёр 2017 онд Астанагийн дээд хэмжээний уулзалтаар ШХАБ-ын бүрэн эрхт гишүүнээр элссэн явдал байв. Тэдний энэ үйлдэл ШХАБ-ын газар зүйн болон хүн ам зүйн хамрах хүрээг эрс тэлж, хүн амын тоогоор дэлхийн хамгийн том бүс нутгийн байгууллага болгов. Стратегийн хувьд энэ тэлэлт байгууллагын олон улсын нэр хүндийг өсгөсөн боловч дотоод зөрчил, ялгаатай ашиг сонирхлыг

нэмэгдүүлсэн. Энэтхэг, Пакистаны сөргөлдөөн, аюул заналын талаарх ялгаатай ойлголт, АНУ-тай харилцах өөр өөр чиг баримжаа нь ШХАБ-ын зөвшилцлийн үндсэн дээр шийдвэр гаргах механизмыг хүндрүүлсэн.

Институцийн хувьд, энэ үеэс ШХАБ уламжлалт бус аюулгүй байдлын асуудалд илүү анхаарал хандуулж эхэлсэн. Кибер аюулгүй байдал, мансууруулах бодисын хууль бус эргэлт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудал ШХАБ-ын тунхаглалуудад онцгой байр суурь эзэлж эхэлсэн хэдий ч шийдвэр нь заавал биелэх зохицуулалтгүй тул бодит шинэчлэлийг хязгаарлаж байв. Иймээс энэ үе шат олон улс дахь ШХАБ-ын нэр хүнд өссөн ч дотоод бүтцийн төвөгтэй байдал гүнзгийрсэн тэнцвэргүй хөгжлийн үе байсан хэмээн дүгнэж болно.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн болон шинэ сорилтуудтай тулгарч буй үе (2018 - өнөөг хүртэл): ШХАБ 2018 оноос хойш Евроазийн бүс нутгийн нэр хүндтэй байгууллага болох байр сууриа бататгасан ч дотоод болон гадаад шинэ сорилттой тулгарсаар байв. Нэг талаас, ШХАБ-ын олон улсын нэр хүнд бэхэжсэн. Тус байгууллага дээд хэмжээний уулзалтаа жил бүр зохион байгуулж, олон талт, бүрэн эрхт байдал, тогтвортой хөгжлийн талаар нэгдсэн байр суурийг илэрхийлсэн. Иран 2023 онд ес дэх бүрэн эрхт гишүүнээр элссэн нь байгууллагын геополитикийн цар хүрээг өргөжүүлж, Баруун Азийн чиглэлд стратегийн холбоог үүсгэсэн. Улмаар 2024 онд Беларусь гишүүнээр элссэнээр ШХАБ-ын үргэлжилсэн тэлэлтийн хандлагыг бататгав. Гэвч ШХАБ шинэ дотоод сорилтуудтай тулгарах болов. Тэргүүлэгч улсын өрсөлдөөн нэмэгдсэнээр Хятадын “Бүс ба Зам” санаачилга Оросын ЕАЭЗХ-ны эзлэх орон зайг шахаж эхэлсэн. Мөн Энэтхэгийн болгоомжтой, хязгаарлагдмал оролцоо нь Хятадын төслүүдэд итгэх итгэл хомс байгааг илтгэж, тодорхой газар зүйн болон стратегийн хуваагдлыг бий болгож байна. Пакистаны эдийн засгийн тогтворгүй байдал идэвхтэй хувь нэмэр оруулах түүний чадамжийг бууруулсан. Гадаад талаас, Өрнөдийн шинжээчид ШХАБ-ыг авторитар дэглэмийг дэмжигч, “олон улсын либерал дэг журмыг эсэргүүцэгч эвсэл” хэмээн шүүмжилсэн хэвээр (Thomas, Catching the ‘Shanghai Spirit’: How the Shanghai Cooperation Organization Promotes Authoritarian Norms in Central Asia 2008 60(8)) байна.

COVID-19 цар тахал ШХАБ-ын боломж болон сул талыг зэрэг илчилсэн явдал болсон. Гишүүн улсууд эрүүл мэндийн хариу арга хэмжээг зохицуулж, вакцины дипломат ажиллагаа явуулсан ч байнгын эрүүл мэндийн механизмыг бий болгоогүй байсан нь институцийн сул талыг илтгэж өгсөн. Үүнтэй адилаар дижитал эдийн засаг, ногоон хөгжил зэрэг хамтын ажиллагааны шинэ чиглэлийг тодорхойлсон ч практик дээр хэрэгжилт хязгаарлагдмал хэвээр байна.

Иймээс энэхүү сүүлийн үе шат олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ч үр ашиг нь тодорхой бус байдалтай байх хөгжлийн үе юм. ШХАБ олон талт хамтын ажиллагааны тавцан хэмээх статусыг олж авсан хэдий ч тунхгуудаа бодит бодлого болгон хэрэгжүүлэх, өөрчлөн, хувиргах чадвар дутмаг хэвээр байна.

Хоёр. ШХАБ-ын төлөвшил, дасан зохицох чадвар, зүй тогтол

ШХАБ-ын хөгжлийн үйл явц дасан зохицох чадвартай байсан хэмээн үзэж байна. ШХАБ дотоод нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөнд өртсөөр ирсэн ба дурдсан үе шат бүрт өөрчлөгдөж буй геополитикийн орчинд уян хатан дасан зохицсоор байсан. Түүний хөгжлийн замнал нэгд, аюулгүй байдлын асуудал ШХАБ-ын үйл ажиллагаанд давамгайл байр суурь эзэлсээр байх; хоёрт, том гүрнүүдийн манлайлах үүрэг (Орос, Хятад) ба бусад гишүүдийнх нь эрх ашгаа хамгаалах тэнцвэр тогтох; гуравт, тунхаг төдий зорилтууд ба бодит хэрэгжилтийн чадамжийн хоорондын зөрчил гэсэн гурван тогтвортой байр суурийг илэрхийлдэг.

ШХАБ байгуулагдсан цагаасаа хойш институцийн хөгжиж, төлөвших дараалсан үе шатыг туулж ирснийг системтэйгээр шинжлэхийн тулд институцийн онол болон харьцуулсан судалгаанд тулгуурлах нь зүйтэй. Эдгээрийн тусламжтай бүс нутгийн байгууллагууд хэрхэн түр зуурын хамтын ажиллагаанаас эхлэн институцжин, өргөжиж, төрөлжих гэсэн тодорхой шатуудыг дамжин хөгждөгийг тайлбарладаг (Rittberger 2006). Түүнчлэн ШХАБ-ын хөгжлийн үйл явцыг бусад бүс нутгийн байгууллагатай харьцуулан үзэх нь түүний институцийн төлөвшлийн онцлогийг ойлгоход тустай юм.

НАТО - өндөр институцилэл бүхий цэргийн эвсэл: Харьцангуй богино хугацаанд өндөр төлөвшилд хүрч, хамтын хамгаалалтын тухай V зүйлийн дагуу гишүүддээ хуулиар заасан үүрэг, хариуцлагыг ногдуулсан. Харин ШХАБ хамтын батлан хамгаалалтаас зайлсхийж, зөвшилцөлд суурилсан уян хатан механизмын төрхөө хадгалсаар буй.

АСЕАН - бүрэн эрхт байдлыг хүндэтгэж, хөндлөнгөөс оролцохгүй байх болон зөвшилцлийг чухалчилдгаараа ШХАБ-тай төстэй загвар юм. Хоёул аль нэг гишүүн-улсад төвлөрсөн эрх мэдэлгүй. АСЕАН эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлд илүүтэй институцилэгдсэн, төслүүд нь бодитоор хэрэгждэг бол ШХАБ аюулгүй байдлын асуудалд түлхүү чиглэсэн хэвээр байна.

Европын Холбоо - бүс нутгийн интеграцийн сайтар хөгжсөн хэлбэр хэмээн үнэлэгдэнэ. Үндэстэн дамнасан засаглал, нэгдсэн тусгаар тогтнолын үндсэн дээр эдийн засаг-улс төрийн гүнзгий интеграццилагдсан бүтэц билээ. Харин ШХАБ-ыг үндэстэн дамнасан эрх мэдлээс санаатайгаар зайлсхийж, интеграцчлалаас илүү бүрэн эрхт байдлыг эрхэмлэдэг хэмээн ойлгож болно.

Энэхүү харьцуулалтаас ШХАБ-ын давуу талыг уян хатан, оролцоог хүртээмжтэй байлгах чадвар хэмээн ойлгож болох бол харин сул талыг нь үр нөлөөний болон хэрэгжилтийн хязгаарлагдмал байдал хэмээн үзэж болно. Түүнчлэн ШХАБ өнгөрсөн хугацаанд олон улсын эргэлзээ, шүүмжлэл дунд тогтвортой оршин байж чадсан явдал түүний геополитикийн тэнцвэрт хандлага, институцийн сөрөн тэсвэрлэх чадавхыг илтгэнэ. Хөгжлийн явцыг нь 2001, 2017, 2023 онд огцом өргөжиж, улмаар зогсонги байдалд орох гэх мэтээр ээлжилсэн шугаман бус зүй тогтолтой байсан хэмээн дүгнэлээ. Харин ШХАБ-ын төлөвшлийн онцлог нь хамрах хүрээг

өргөжүүлэхэд чиглэж (гишүүнчлэл, үйл ажиллагааны салбар, чиглэл) байснаас бус институцийн уялдаа, хэрэгжилтийн механизмыг хөгжүүлэхэд сул анхаарчээ. Иймээс өнөөгийн ШХАБ-ыг хамрах хүрээ, нэр хүнд, гишүүнчлэлийн хувьд төлөвшсөн хэдий ч биелэгдэхүйц үүрэг, хэрэгжилтийн хувьд гүехэн бүс нутгийн байгууллага гэж үзэж болно. Энэхүү төлөвшлийн загвар ШХАБ-ыг нэг талаас прагматик аюулгүй байдлын платформ, нөгөө талаас олон талт ертөнцийн бэлгэдлийн нэг хэлбэр болохыг харуулахын зэрэгцээ XXI зууны Өрнөдийн бус бүс нутгийн интеграцийн сонирхолтой тохиолдлуудын нэг болгож байна.

Гурав. ШХАБ-ын динамик төлөв, онцлог

ШХАБ-ын хөгжлийн үе шат, институцийн төлөвшлийн үйл явцыг нэгтгэн шинжилбэл тус байгууллага олон талт, зөрчилтэй боловч уян хатан динамик бүтэцтэй болох нь илэрхий байна. ШХАБ нэг талаас тэсвэртэй, тогтвортой бүс нутгийн байгууллага бол нөгөө талаас сул институцчилагдсан, гүйцэтгэл дутмаг тогтолцоо болно. Түүнчлэн, аюулгүй байдлын прагматик хамтын ажиллагаа болон олон талт дэг журмыг зэрэг илэрхийлэгч платформ юм. Энэ хэсэгт ШХАБ-ыг бүс нутгийн интеграцийн түвшинд авч үзэн, динамик төлөв, онцлогийг шинжилсэн болно.

Тогтворгүй орчин дахь тэсвэртэй байдал: ШХАБ-ын гол амжилт бол түүний тэсвэртэй, удаан хугацаанд оршин тогтнох чадвар юм. Евроазийн орон зайн болон бүс нутгийн санаачилгууд богино настай, өрсөлдөөн дүүрэн байсан сүүлийн 20 гаруй жилийн турш ШХАБ зөвхөн оршин тогтноод зогсохгүй, хамрах хүрээгээ тэлж, өргөжиж чадсан. Евроази нь том гүрнүүдийн өрсөлдөөн бүхий, хэврэг төрт улсууд, давхардсан бүс нутгийн байгууллагуудтай онцлог бүс нутаг боловч ийм нөхцөлд ШХАБ байр сууриа тогтвортой хадгалж иржээ. Түүний удаан хугацаанд оршин тогтносоор байгааг дараах гурван хүчин зүйлтэй холбон үзэж болно.

Нэгдүгээрт, гишүүн улсуудынхаа бүрэн эрхийг хүндэтгэх, дотоод хэрэгт нь үл оролцох, зөвшилцөж байж шийдвэр гаргах зарчмуудыг тэргүүнд тавин, тэдний дотоод тогтвортой байдал, дэглэмийн аюулгүй байдлыг хангах замаар хамтын ажиллагааг өргөжүүлж чадаж байгаа нь норматив уян хатан байдлыг нь илтгэж байна. Харин эхэндээ аюулгүй байдлын асуудалд түлхүү төвлөрч байсан ч, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, дижитал хамтын ажиллагаа зэрэг шинэ чиглэлд үйл ажиллагаагаа тэлэх замаар өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицохоор зорьж байгаа нь үйл ажиллагааных нь уян хатан байдлын илрэл болж буй.

Хоёрдугаарт, Энэтхэг, Пакистан, Ираныг элсүүлснээр ШХАБ пан-Евроазийн тавцан болон өргөжиж, олон улсын нэр хүндээ өсгөсөн. Ийнхүү өргөжиж, тэсэж үлдсэн явдал Зөвлөлтийн дараа байгуулсан бусад байгууллагын хувь заяатай харьцуулахад ямартаа ч ололт юм. Тодруулбал: ТУХН болон бусад интеграцийн механизмын үйл ажиллагаа саармагжин, зарим нь бүрэн задран унасан бол ШХАБ динамик, оршин тогтнох чадвартай хэвээр үлдсэн.

Гуравдугаарт, өмнө ШХАБ-ын хөгжлийн замнал шугаман бус төлөвшлийн загварыг илэрхийлдэг ба дөрвөн үе шатаар дамжин хөгжсөн талаар дурдсан. Эдгээр

үе шат бүрт тухайн цаг үеийн геополитикийн өөрчлөлтөд ШХАБ дасан зохицсоор ирсэн. Тухайлбал: 2001 онд АНУ Төв Азид цэргийн оролцоогоо нэмэгдүүлэхтэй зэрэгцэн ШХАБ аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа өргөжүүлж эхэлсэн. Мөн 2013 онд Хятадын “Бүс ба Зам” санаачилга гарсантай холбоотойгоор эдийн засгийн чиглэлийн талаар ярилцаж эхэлсэн байдаг. Улмаар 2014 оноос Орос-Өрнөдийн харилцаа хурцдахтай зэрэгцэн Евроазийн эв нэгдэл, олон талт байдлын платформ болон төлөвшсөн.

Харин ШХАБ-ын хамрах хүрээ өргөжсөн ч үйл ажиллагаа, институцлэл сул хэвээр байна. Гишүүнчлэлийн хүрээгээ өргөжүүлж, үйл ажиллагааны чиглэлээ төрөлжүүлэн, дипломат нэр хүндээ өсгөсөн боловч институцийн бүтэц, хэрэгжилтийн механизм нь НАТО, ЕХ зэрэг байгууллагын түвшинд хүрээгүй байна. Өмнө дурдсанаар НАТО хамтын батлан хамгаалах тохиролцоотой, ЕХ үндэстэн дамнасан эрх мэдэлтэй бол ШХАБ зөвшилцөлд суурилсан, хязгаарлагдмал бюрократ бүтэцтэй хэвээр байна. Өөрөөр хэлбэл: ШХАБ хамрах хүрээ, нэр хүнд, гишүүнчлэлийн хувьд төлөвшсөн, харин институцийн чадамж, хэрэгжилтийн хувьд бүрэн төлөвшөөгүй байгууллага юм. Энэ нь түүнийг зэрэгцэн орших хоёр шинжтэй буюу өргөн цар хүрээтэй боловч гүехэн бүтэцтэй бүс нутгийн байгууллага хэмээн тодорхойлоход хүргэнэ.

ШХАБ-ын динамик төлөв олон талт тогтолцоонд өрнөж буй өргөн хүрээний өөрчлөлтийг илэрхийлж байна. Олон талт байдал гүнзгийрэхийн хэрээр том гүрнүүдийн өрсөлдөөнд зуучлах болон ялгаатай засаглалын хувилбаруудыг бий болгох бүс нутгийн байгууллагуудын үүрэг улам бүр нэмэгдэж байна. ШХАБ энэхүү чиг хандлагын тод илрэл болох ба Хятадын баруун хилийн тогтвортой байдлыг ханган, “Бүс ба Зам” санаачилгыг нь дэмжих стратегийн платформ юм. Харин Орост Евроазийн үзэл санааг бэхжүүлэх, Өрнөдийн нөлөөг тэнцвэржүүлэх хэрэгсэл нь ШХАБ болж байна. Төв Азийн улсуудын тухайд бүрэн эрхт байдлыг нь хамгаалах, аль нэг том гүрний хэт нөлөөнд автахгаас сэргийлэх “олон талт хамгааллын хүрээ” болох аж. Энэтхэг, Пакистанд Евроазийн асуудалд оролцох боломжийг ШХАБ олгож байж болох ч, тэдний сөргөлдөөн үр нөлөөтэй байдлыг нь хязгаарлаж байна. Харин Иран ШХАБ-ын гишүүн болсноор олон улсын тавцанд хууль ёсны байр сууриа бэхжүүлж, тусгаарлалтаас гарах дипломат гарцыг олж авна хэмээн найдсан ч санаснаар болох эсэх нь эргэлзээтэй.

Эдгээр олон талын ашиг сонирхлыг зэрэг багтааж байгаа нь ШХАБ-ыг “олон ургалч” олон талт хамтын ажиллагааны жишээ болгож байгаа юм. Өөрөөр хэлбэл: өнөөгийн дэлхийн дэг журам төвлөрсөн, ижил хэв маягтай институциудаар бус, харин бүс нутгийн онцлог, хүчний тэнцвэрийг тусгасан олон, ялгаатай бүс нутгийн байгууллагаас бүрэлдэж байна.

Дүгнэлт

ШХАБ-ын үүсэл, бүтэц, үйл ажиллагааны динамик, төлөвшлийн үе шатуудыг дээрх байдлаар шинжлэн үзвээс ШХАБ нь Өрнөдийн оролцоогүй бүс нутагчлалын

шинэлэг загвар болох хандлагыг илэрхийлнэ хэмээн үзэж байна. НАТО эсвэл ЕХ-ноос ялгаатай нь ШХАБ аливаа заавал биелүүлэх үүрэг амлалтаас зайлсхийдэг. АСЕАН-аас ялгаатай нь эдийн засгийн интеграцчиллын механизмгүй. Академик талаас авч үзвэл ШХАБ бүс нутагчлалын олон ургалч онолын тусгал болж байна (Acharya). Энэ онол ёсоор бүс нутгийн институтууд Өрнөдийн загварыг хуулбарлах бус тухайн бүс нутгийн онцлог, соёл, хэм хэмжээ, хүчний тэнцвэрийг тусгасан ялгаатай логик бүхий байж болно. ШХАБ-ын ач холбогдол заавал бодит үр дүнд тэмүүлэх бус харин олон талт хамтын ажиллагааны шинэ хэм хэмжээ тогтооход оршиж байгаа юм.

ШХАБ-ын хөгжлийн явц, динамик төлөвийг ойлгох нь Монгол Улс цаашдын оролцоогоо хэрхэн тодорхойлоход чухал ач холбогдолтойн дээр хорь гаруй жил ажигласны эцэст шинээр бүрэлдэж байгаа нөхцөл байдалд хэрхэн дасан зохицохоо эрэлхийлэх нь зүйтэй болов уу.

Эх сурвалжийн жагсаалт

Acharya, A. n.d. “The role of the “Global South” in a multiplex world: Interview with Professor Amitav Acharya.” *Vestnik of the Peoples’ Friendship University of Russia. Series: International Relations*.

Kaczmarek, M. 2017 93: 6. “Non-western visions of regionalism: China’s New Silk Road and Russia’s Eurasian Economic Union.” *International Affairs* 1376.

Rittberger, Volker. 2006. *International organization: polity, politics and policies*. New York: Palgrave-Macmillan.

Thomas, Ambrosio. 2008 60(8). “Catching the ‘Shanghai Spirit’: How the Shanghai Cooperation Organization Promotes Authoritarian Norms in Central Asia.” *Europe-Asia Studies, Taylor & Francis Journals* 1321-1344.

Thomas, Ambrosio. 2008 60(8). “Catching the ‘Shanghai Spirit’: How the Shanghai Cooperation Organization Promotes Authoritarian Norms in Central Asia.” *Europe-Asia Studies, Taylor & Francis Journals* 1321-1344.

Tiezzi, Shannon. 2015. ““Russia’s ‘Pivot to Asia’ and the SCO: Richard Weitz on Russia’s “pivot to Asia,” Sino-Russia relations, and the future of the SCO.” <https://thediplomat.com/2015/07/russias-pivot-to-asia-and-the-sco/>. 07 21.

A Analysis of the SCO's dynamic evolution and developmental stages

Soyolgerel Nyamjav

Ph.D., candidate, soyolgerel@iss.gov.mn

Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

Abstract

The “Shanghai Five” process was initiated in 1996 when Russia, the People’s Republic of China, Kazakhstan, Kyrgyzstan, and Tajikistan signed the “Agreement on Confidence-Building Measures in the Border Areas” in Shanghai, China. In its early period, the activities of this structure focused on confidence-building in the military sphere and security-related matters. The member states subsequently decided to further institutionalize their cooperation, and in 2001, with the addition of Uzbekistan, announced the establishment of the Shanghai Cooperation Organisation (SCO). Furthermore, with the signing of the SCO Charter in 2002, the SCO was formally constituted as an intergovernmental political consultative mechanism aimed at addressing common security challenges in Central Asia and promoting regional cooperation.

Over the intervening period, the organization has expanded through the admission of India, Pakistan, Iran, and Belarus as full members. The SCO has evolved into not merely a platform for dialogue and cooperation among its members and a format for engagement with other regional and international organizations, but a major regional mechanism for promoting stability, security, and development across Eurasia.

This paper seeks to examine the SCO’s development by categorizing it into distinct stages of growth, and to assess its increasingly dynamic character.

Keywords: *Regional cooperation, security activities, great powers, interest*